



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 418

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,  
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 32 дугаар тогтоол, Дундговь аймгийн Засаг даргын 2019 оны А/212 дугаар захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 107,164,813.25 (нэг зуун долоон сая нэг зуун жаран дөрвөн мянга найман зуун арван гурван төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 558,150.06 (таван зуун тавин найман мянга нэг зуун тавин төгрөг зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө (барилга), 4,968,000.00 (дөрвөн сая есөн зуун жаран найман мянган) төгрөгийн балансын үнэ бүхий газар эзэмших эрхийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа Дундговь аймаг дахь Шүүхийн шинжилгээний албандаа эзэмшүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал, Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Дундговь аймгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

3.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД

0000848

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн  
48. дугаар тогтооплын хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨМЧӨОС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ,  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХАРЬЯА ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
АЛБАНД ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Үндсэн хөрөнгийн нэр, Марк	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хурумтлагдсан эзэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
<b>1.Барилга</b>						
1	Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн барилга (Дундговь аймаг, Сайнцагаан сум, 2 давхар)	2008	164.40 м2	107,164,813.25	558,150.06	106,606,663.19
	Дүн			107,164,813.25	558,150.06	106,606,663.19
<b>2.Газар</b>						
1	Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн барилгын газар эзэмших эрх	2019	414 м2	4,968,000.00	-	4,968,000.00
	Дүн			4,968,000.00	-	4,968,000.00
	Нийт дүн			112,132,813.25 (нэг зуун арван хоёр сая нэг зуун гучин хоёр мянга найман зуун арван гурван төгрөг хорин таван мөнгө)	558,150.06 (таван зуун тавин найман мянга нэг зуун арван гурван төгрөг зураган мөнгө)	111,574,663.19 (нэг зуун арван нэгэн сая таван зуун далан дөрвөн мянга зураган зуун жаран гурван төгрөг арван есөн мөнгө)